# ДУНДГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

## 2019 оны наймдугаар сарын байдлаар



# ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ– Төсөв

**төсвийн орлого, зарлага / сая төгрөг /**

| | 2018 I-VIII | 2019 I-VIII |
|---|---|---|
| орлого | 26 702.3 | 28 819.9 |
| зарлага | 23 221.3 | 25 691.0 |

**төсвийн орлогод эзлэх хувь 2019 оны 8 сарын байдлаар**



# ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ– Банк

## МОНГОЛ БАНК МЭДЭЭ / сая төгрөг /

| 2018 I-VIII | | 2019 I-VIII |
|---|---|---|
| 49 142.8 | ИРГЭДИЙН ХАДГАЛАМЖ | 46 543.9 |
| 104 893.7 | ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ | 117 604.7 |

**Банкны зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 12.1 хувиар өсч 117604.7 сая төгрөг болжээ. Үүнээс анхаарал хандуулах зээл 1095.7 сая төгрөг, чанаргүй зээл 1177.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж өмнөх оны мөн үеэс анхаарал хандуулах зээл 6.6 хувь, чанаргүй зээл 20.6 хувиар тус тус нэмэгдсэн байна**

# ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – АЖ ҮЙЛДВЭР

## АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ /САЯ.ТӨГ/




**Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 2019 оны 8 сарын байдлаар 2046.7 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 10.3 хувиар өссөн байна.**

# ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Эрүүл мэнд



## Эмнэлэгт эмчлэгдэж гарсан хүний тоо, амбулаторийн үзлэгийн тоо

| | 2017 I-VIII | 2018 I-VIII | 2019 I-VIII |
|---|---|---|---|
| Эмчлэгдэн гарсан хүний тоо | 7221 | 7665 | 7398 |
| Амбулаторийн үзлэгийн тоо | 99205 | 111594 | 113741 |

Тухайн сарын байдлаар стационарит шинээр 7387 эмчлүүлэгч хэвтэж, 7398 эмчлүүлэгч эмнэлгээс гарсан бөгөөд нийт 52196 ор хоног ашиглаж, дундаж ор хоног 7.1 байна. 2019 оны 8 сарын байдлаар 113741 амбулаторийн үзлэг бүртгэгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 29.4 %, амбулаторийн үзлэг 47.5 %, идэвхтэй хяналт 16.4 %, гэрийн үзлэг 4.8 %- ийг эзэлж байна. Нийт үзлэгт хамрагдсан хүмүүсийн 35.0 хувь нь эрэгтэй, 65.0 хувь нь эмэгтэй хүн байна.

# ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Эрүүл мэнд

| | Амаржсан эхийн тоо | Амьд төрсөн хүүхдийн тоо | 0-1 насны хүүхдийн эндэгдэл | 1-5 насны хүүхдийн эндэгдэл |
|---|---|---|---|---|
| 2017 I-VIII | 577 | 581 | 6 | 2 |
| 2018 I-VIII | 626 | 632 | 5 | 3 |
| 2019 I-VIII | 600 | 608 | 1 | 1 |

Эрүүл мэндийн газрын мэдээгээр аймгийн хэмжээнд 2019 оны 8-р сарын байдлаар 600 эх төрсөн ба нийт 608 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 24 тохиолдолоор буурсан байна. Төрсөн эхчүүдийн 88.5 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт төрсөн байна. Тус аймагт энэ сарын байдлаар эхийн эндэгдэл гараагүй бөгөөд, 0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл Эрдэнэдалай суманд 1 гарсан байна.

# ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Эрүүл мэнд

## Бүртгэгдсэн халдварт өвчлөлийн тоо




Халдварт өвчний 272 тохиолдол бүртгэгдээд байгаа нь урьд оны мөн үеэс 12 тохиолдлоор өсч, 10000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 58.4 болж өмнөх оны мөн үеэс 1.8 пунктээр өссөн байна

# ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ - Хөдөлмөр

## АЖИЛ ХАЙГЧ ИРГЭН, жил бүрийн 8 сарын байдлаар




| | 2017 I-VIII | 2018 I-VIII | 2019 I-VIII |
|---|---|---|---|
| Ажил хайгч иргэн | 667 | 543 | 385 |
| Үүнээс эмэгтэй | 350 | 281 | 187 |

**2019 оны 8 сарын байдлаар аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газарт бүртгэлтэй, ажил хайж байгаа 385 хүн бүртгэгдсэн нь өмнөх сартай харьцуулахад 26.8 хувиар буурсан байна. Нийт ажилгүйчүүдийн 48.5 хувь буюу 187 хүн нь эмэгтэйчүүд байна.**

# ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ - Хөдөлмөр

## Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажилгүйчүүд, 2019 оны эхний 8 сарын байдлаар, сумаар






аймгийн хэмжээнд **126**

**Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн насны 10000 хүнд 126 ажил хайгч иргэн ногдож байхад Говь-Угтаал 284, Баянжаргалан 250, Сайхан-Овоо-208, Эрдэнэдалай 167, Гурвансайхан 191, Дэлгэрхангай 176 байгаа нь аймгийн дунджаас дээгүүр байна.**

# ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ - Хөдөлмөр

## НИЙГМИЙН ХАЛАМЖИД ХАМРАГДСАН ХҮНИЙ ТОО
## 2019 оны 8 сарын байдлаар

**ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР**
777 ИРГЭН

**ХАЛАМЖИЙН ТЭТГЭМЖ**
1667 ИРГЭН

**АЛДАРТ ЭХИЙН ОДОН**
4518 ИРГЭН

**НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ**
1 117 ИРГЭН

**ОЛОН ХҮҮХЭДТЭЙ ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭХ, ЭЦЭГ**
3835 ИРГЭН

**НАСНЫ ХИШИГ**
2 526 ИРГЭН

**БУСАД**
390 ИРГЭН

2019 оны эхний 8 сарын байдлаар нийгмийн халамжийн сангаас 15640 хүнд 4566.5 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмж, халамжийг олгосон байна.

# ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Гэмт хэрэг

## БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДОГЧДЫН ТОО, жил бүрийн 8 сарын байдлаар




Цагдаагийн хэлтсийн 2019 оны 8 сарын байдлаар аймгийн хэмжээнд нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 145 болж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 0.6 хувь болж буурсан байна. Гэмт хэрэгт холбогдогчдын тоо өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 23.8 хувиар буурч 67 хүн холбогдоод байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 348.8 сая төгрөг, түүний 27 хувь буюу 94.1 сая төгрөгийг нөхөн төлүүлээд байна. Гэмт хэрэг илрүүлэлтийн хувь аймгийн хэмжээнд өмнөх оны мөн үеэс 6.3 хувиар өсч, 43.7 хувь болсон байна.

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО




**1212.mn** аппликейшнаас

# СТАТИСТИКИЙН

мэдээллээ аваарай

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН